



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/29

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Баатархайрхан багийн нутаг дэвсгэр Шинэ суурьшлын бүсэд 0,5 га газрыг Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги /9066543/-д ажилчдын орон сууц, албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-д даалгасугай.

3.Аймгийн хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



02 00123  
D/Zax-A/29-Da